



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2016 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/314

Булган

Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх
тусгай зөвшөөрлийн тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь заалт, 16 дугаар зүйлийн 2.5 дахь заалт, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4.3, 4.7 дахь заалт, Монгол улсын Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны 121-р тогтоол, 2013 оны 57-р тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл” хүсч холбогдох стандарт, хууль, журмын шаардлага хангасан, чанар аюулгүй байдлыг баталгаажуулсан тохирлын гэрчилгээ бүхий цэгүүдийн согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмших эрхийг 2 жилийн хугацаатай шинээр олгосугай.

2. Монгол улсын Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2011 оны 121-р тогтоолд заасны дагуу “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл”-ийн хугацаа сунгахад тушаах тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төрийн санд төвлөрүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл” шинээр авах аж ахуйн нэгжийн нэрсийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.


ЗАСАГ ДАРГА



Д. ЭРДЭНЭБАТ

/My doc-2016/

Аймгийн Засаг даргын 2016 оны 04 сарын 05
өдрийн 1/314 тоот захирамжийн нэгдүгээр хавсралт



**“СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ” ШИНЭЭР АВАХ ЦЭГИЙН ЖАГСААЛТ**

№	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн овог, нэр	Үйлчилгээний төрөл	Үйлчилгээний газрын нэр
1	Булган	“Их-Ураг” ХХК	П.Ганзул	Хүнсний дэлгүүр	“Арвай”
2	Булган	“Их-Ураг” ХХК	П.Ганзул	Баар	“Арвай”
3	Баяннуур сум	“Арвин түншлэл” ХХК	А.Лхагэрэл	Хүнсний дэлгүүр	“Мини маркет”
	Нийт-3				